



МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН САЙДЫН
ТУШААЛ

2016 оны 01 сарын 07 өдөр

Дугаар 04

Улаанбаатар хот

Нислэгийн шугамыг хуваарилах,
агаарын тээвэрлэгчийг томилох тухай

Иргэний нисэхийн тухай Монгол Улсын хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3, 7.1.11 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Улаанбаатар – Өлгий – Усть-Каменогорскийн чиглэлд олон улсын нислэгийн чиглэлийг нээсүгэй.

2. Улаанбаатар – Өлгий – Усть-Каменогорск – Өлгий – Улаанбаатарын олон улсын нислэгийн чиглэлийг агаарын тээврийн “Аэромонголиа” ХХК-д хуваарилан, нислэг үйлдэх агаарын тээвэрлэгчээр томилсугай.

3. Дээрх нислэгийн чиглэлд агаарын тээврийн “Аэромонголиа” ХХК-ийг томилж байгаа талаар Бүгд Найрамдах Казакстан Улсын эрх бүхий байгууллагад мэдэгдэх зохион байгуулалтын арга хэмжээ авахыг Төрийн нарийн бичгийн дарга Ж.Бат-Эрдэнэд даалгасугай.

4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан агаарын тээврийн “Аэромонголиа” ХХК-д нислэг үйлдэхэд шаардагдах бэлтгэл хангах, нислэгийн аюулгүй ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Иргэний нисэхийн ерөнхий газар /Г.Нямдаваа/-т үүрэг болгосугай.

САЙД



М.ЗОРИГТ